



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/223

Ховд

Барилгын захиалагчийн хяналтын орон
тооны бус ажлын хэсэг байгуулах тухай

Барилгын тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.2.4 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймагт 2019 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд барилгын захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх орон тооны бус ажлын хэсгийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэд дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

- | | |
|--------------------|---|
| ахлагч: Р.Цэдэнбал | - Монгол улсын гавьяат барилгачин, өндөр настан /зөвшилцсөнөөр/ |
| Р.Сандуйжав | - Монгол улсын гавьяат барилгачин, өндөр настан /зөвшилцсөнөөр/ |
| Г.Цогтдэлгэр | -Ахмад барилгачин /зөвшилцсөнөөр/ |
| Н.Амаржаргал | -Сантехникийн инженер |
| Б.Одсүрэн | -Цахилгааны инженер |
| Б.Амаржаргал | -Монгол улсын мэргэшсэн төсөвчин |

Нарийн бичгийн

- | | |
|------------------|--|
| дарга: З.Өмиртай | - Аймгийн ерөнхий архитектор бөгөөд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга |
|------------------|--|

2.Барилгын захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын удирдлага доор хамтарч хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч / Р.Цэдэнбал/-д үүрэг болгосугай.

Зах А/223 Чх
02 01086

3.Холбогдох зардал, томилолт олгох, унаа автомашин ашиглуулан хамтран хяналтыг хэрэгжүүлж арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /С.Гантөмөр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

4.Хууль эрх зүйн баримт бичиг, барилгын норм ба дүрэм, багаж тоног төхөөрөмжийг ашиглуулан хамтран хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/ нарт даалгасугай.

5.Барилгын захиалагчийн хяналтыг холбогдох хууль, журам, дүрмийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал бүрээр гаргаж танилцуулж байхыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ.

